

**ДАЛАЙН ЗАХИРГААНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 4-Р УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

**2022.12.07**

| Д/д | Зорилго   | Хэрэгжүүлэх арга хэмжээ  | Хэрэгжилт  |
|-----|---|--|--|
| 1   | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх              | Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасны дагуу авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар АТГ-аас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж биелэлтэд хяналт тавьж ажиллах  | АТГ-аас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр батлан хэрэгжүүлж байна.  |
| 2   | Авлигын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, дарга, удирдах албан тушаалтныг авлигад өртөхөөс урьдчилан сэргийлэх | Байгууллагын удирдах болон эрх бүхий албан тушаалтны Албан тушаалын тодорхойлолтыг эрхлэх асуудал, ажлын байрны чиг үүрэг, албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, туршлага, ур чадварын шаардлагад нийцүүлэн нэгдсэн стандартын дагуу шинэчлэн боловсруулж мөрдүүлэх  | Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан “Далайн захиргааны албан хэрэг хөтлөлт, санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх тухай” удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийсэн Ажлын хэсгийн тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Далайн захиргааны нийт албан тушаалын тодорхойлолтыг мэргэжлийн шаардлага, дүрэм, журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн сайдаас батлах зөвшөөрөл авахаар 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 1/169 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.   |
| 3   | Сул гарсан орон тоог нөхөхдөө авлигаас ангид зохион байгуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх                                  | Нийтийн албаны томилгоо, сул орон тоо гарсан тохиолдолд сонгон шалгаруулалтыг нээлттэй ил тод болгож, иргэдийг нийтийн албанд орох адил тэгш боломжоор хангах, нийтийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангуулах арга хэмжээг байгууллагын холбогдох журамд /байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, Далайн захиргааны дүрэмд сул орон тоо гарсан тохиолдолд сонгон шалгаруулалтыг нээлттэй ил тод болгож иргэдийг нийтийн албанд орох адил тэгш боломжоор хангах үүднээс тодорхой тусгаж хэрэгжүүлж ажиллаж байгаа бөгөөд 2022 он гарсаар Далбааны эзэн улсын хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн, Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Мэдээллийн сүлжээ, техник хангамж хариуцсан мэргэжилтэн, Усан замын тээврийн хяналт хариуцсан мэргэжилтний ажлын байрны сонгон шалгаруулалтыг өөрийн цахим хуудсаар нийт давхардсан тоогоор 12 удаа зарлан ажилласан. |
| 4   | Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх   | Төрийн албанаас чөлөөлөгдсөн, халагдсан улмаар авлига, албан тушаалын болон өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдийг нийтийн албан   | Хөдөлмөрийн дотоод журмыг Хөдөлмөрийн тухай шинэ хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, Далайн захиргааны даргын 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 59 дүгээр тушаалаар батлуулсан ба тус   |

|   |  |   |  |
|---|--|---|--|
|   |  | тушаалд томилохгүй байх талаар холбогдох журамд тусган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах   | журмын 4.2.4-т “Удирдах ажилтан хууль зөрчсөн, ёс зүйн алдаа гаргаж ажлын хариуцлага алдсаны улмаас чөлөөлөгдсөн бол дахин удирдах ажилд томилохгүй байх” тухай зохицуулалтыг тусгасан.  |
| 5 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах         | Нийтийн албан тушаалтны давхар ажил эрхлэлтийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, давхар ажил эрхлэлттэй холбоотой ажил, үүргийг гүйцэтгэхгүй байх талаар холбогдох журамд тусган хэрэгжүүлэх  | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 57 дугаар зүйлийн дагуу байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 3.17, 3.18 дахь хэсгүүдэд холбогдох зохицуулалтыг тусгасан.   |
|   |  | Төсөв санхүү худалдан авах ажиллагаанд хяналт тавих талаар холбогдох зөвлөлийн ажиллах журам ажлын төлөвлөгөөнд тусган ажиллах  | Төсөв санхүү худалдан авах ажиллагаанд хяналт тавих тухай асуудлыг байгууллагын Хяналт шинжилгээ, дотоод, аудитын зөвлөлийн ажиллах журамд тусган хэрэгжүүлж ажиллаж байна. 2022 оны байгууллагаас зарласан худалдан авах ажиллагааны Үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй талаар мэдэгдэл гаргаж ажилласан. |
|   |  | Бусдад давуу байдал олгох, ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргах буюу хамаарал бүхий этгээд, нэгдмэл сонирхолтой этгээдтэй холбоотой тушаал шийдвэр гаргах, гаргахад оролцох, гэрээ хэлцэл байгуулах, албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөх зэрэг авлига, ашиг сонирхлын зөрчлийг гаргахгүй байх талаар Ажилтны ёс зүйн дүрэм болон тэдэнтэй байгуулах Хөдөлмөрийн гэрээнд тусган хэрэгжүүлж ажиллах | Авлига ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх талаар байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 2.1.4 дэх хэсэгт болон Ажилтны ёс зүйн дүрэм, мөн Хөдөлмөрийн гэрээнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.  |
| 6 | Авлигад өртөж болзошгүй эрсдэлтэй ажил албан тушаалтныг авлигад өртөхөөс урьдчилан сэргийлэх | Авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөж болзошгүй эрсдэлт ажил, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн гаргаж баталгаажуулах   | Авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөж болзошгүй ажил, албан тушаалын жагсаалтыг Далайн захиргааны даргын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 19 дүгээр тушаалаар батлуулсан ба Хяналт шинжилгээ, дотоод аудитын зөвлөл хяналт тавин ажиллаж байна.  |
| 7 | Хөрөнгө мөнгө зарах үйл ажиллагаанд авлигаас ангид байх нөхцөл боломжийг бүрдүүлэх           | Гэрээ байгуулах, хяналт шалгалт явуулах, Тендер, сонгон шалгаруулалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа албан тушаалтнаар хувийн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүр гаргуулж хэвшүүлэх   | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Тендер шалгаруулалт бүрд Далайн захиргааны даргын тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны гишүүд тендерт оролцогч компаниудтай ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл тус тус гаргаж хэвшээд байна.    |